



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Матад сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДОА-2020/11/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: [tsengelmaav@audit.gov.mn](mailto:tsengelmaav@audit.gov.mn)

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: [khaanconsultingaudit@gmail.com](mailto:khaanconsultingaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам Тээвэр Хөгжлийн Сайд
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам



## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	2
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	8
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

№ Д.А. 02.27 № 180

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Матад сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Матад сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Матад сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520090



**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## **2.1. Оршил**

Матад сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Амарсанаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Матад сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Матад сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Матад сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Матад сумын Соёлын төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Албан газар, аж ахуйн нэгж, иргэд, хөдөөгийн хөдөлмөрчид, хүүхэд багачуудын дунд тэдний хэрэгцээ сонирхолд түшиглэн соёл чөлөөт цагийн олон төлт ажлыг зохион байгуулах”-д оршино.

Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Иргэд, ардын авъяастны дунд тэдний хэрэгцээ, сонирхолд түшиглэн соёл чөлөөт цагийн олон талт ажлыг зохион байгуулах
- Байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, ардын авъяастныг түшиглэн үндэсний уламжлалт болон хүүхдэд зориулсан урлаг, сонгодог урлагийг сурталчлан дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах чиглэлээр сургалт явуулж, хамтлаг, хэсэг зохион байгуулан хүн амын соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Матад сумын Соёлын төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Матад сумын Соёлын төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ахplorer” программ хангамж ашигладаг байна.

Матад сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд



байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 29 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 57,999.6 мянган төгрөгөөс тооцон 1,159.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд тооцсонг хэвээр авсан.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Матад сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,178.04 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Бараа материал	28,023.56	37,554	9,530.9
Үндсэн хөрөнгө	385,504.98	400,048.1	14,543.2
Хуримтлагдсан элэгдэл	(58,575.53)	(45,471.5)	13,103.99
<b>Нийт хөрөнгө</b>	<b>354,953.00</b>	<b>392,131.04</b>	<b>37,178.04</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	354,953.00	392,131.04	37,178.04
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>354,953.00</b>	<b>392,131.04</b>	<b>37,178.04</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь урлагын хувцас хэрэглэлд шинэчлэл зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр урлагын хувцас худалдан авсантай холбоотой байна.



Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын 2,720.6 мянган, бичиг хэргийн 148.6 мянган, аж ахуйн 8,570.9 мянган, түлш шатах тослох материалын 851.7 мянган, 9586,0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Сумын хөрөнгө оруулалтаар 15,850.4 мянган төгрөгийн барилга байгууламж, 1.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 650.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, бусад хөрөнгө 7,059.9 мянган төгрөгийн бусад хөрөнгө, БСШУСЯ-ны хандиваар 319.4 мянган төгрөгийн ном хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн/ буурсан өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 567,678.2 мянган төгрөг болж 29,653.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 68,995.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 68,995.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 68,995.8 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Матад сумын Соёлын төв 2019 онд өөрийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

## **2.11. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 39 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,032.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 148.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,687.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 197,2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 1,835.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 2019 оны 7-р сарын нийт цалинг буруу тооцоолсон байсан ба дахин тооцоолоход зөрүү 148.3 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “Нягтлан бодох бүртгэлт хөтлөх” 14.3 дахь заалтын 14.3.1 дахь хэсэгт



заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд гарсан зардлаас 1,687.4 мянган төгрөгийн зардлыг ибаримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахв Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллалаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 197.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

1. Кассын тайлан, билетийн тооцоо зэрэг бэлэн мөнгөний баримтуудын иж бүрнээр нь бэлтгэж байх. Орлогын эх үүсвэрийг тодорхой хөтлөн бүртгэлд тусгах.
2. Соёлын төв өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон жишиг НБББББ-г ашиглан боловсруулж санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглах

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Матад сумын Соёлын төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 132 мэдээллийг хугацаанд нь, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Матад сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Матад сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтанд заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор шатахуун зарцуулалтыг дахин тооцоолоход 197.2 мянган төгрөгийн зөрүүтэй байсан.

1.2 Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.

1.3 Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтанд ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалыг мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,023,555.00</b>	<b>37,554,455.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,023,555.00	37,554,455.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	8,342,439.00	8,572,839.00
35110	Тусгай зориулалттай материал	8,342,439.00	8,572,839.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,681,116.00	28,981,616.00
35420	Аж ахуйн материал	12,905,467.00	12,939,467.00
35470	Бусад хангамжийн материал	6,775,649.00	16,042,149.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>326,929,447.10</b>	<b>354,576,589.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	326,929,447.10	354,576,589.84
<b>392</b>	<b>Биег хөрөнгө</b>	322,917,447.10	350,564,589.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	30,747,814.20	30,747,814.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,306,163.00)	(27,046,438.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,736,763.00	32,593,651.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,627,784.20)	(12,301,220.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,035,900.40	21,722,164.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,443,083.62)	(4,828,131.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	972,500.00	10,972,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(198,499.68)	(1,295,749.72)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	300,000,000.00	300,000,000.00
<b>393</b>	<b>Биег бус хөрөнгө</b>	4,012,000.00	4,012,000.00
39303	Бусад биег бус хөрөнгө	4,012,000.00	4,012,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>354,953,002.10</b>	<b>392,131,044.84</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>354,953,002.10</b>	<b>392,131,044.84</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	354,953,002.10	392,131,044.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352,928,413.40	352,928,413.40
51101	Өмч: - төрийн	352,928,413.40	352,928,413.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,024,588.70	39,202,631.44
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,147,765.62)	(3,147,765.62)
51220	Тайлант үеийн үр дүн	-	37,178,042.74
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	5,172,354.32	5,172,354.32
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>354,953,002.10</b>	<b>392,131,044.84</b>



Матад сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	59,390,000.00	105,261,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,832,400.00	40,165,200.00
121	Хөрөнгийн орлого	930,000.00	31,165,200.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	930,000.00	31,165,200.00
122	Тусламжийн орлого	11,902,400.00	9,000,000.00
122001	Хандиа тусламж /дотоод/	11,902,400.00	9,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТНИЙН ОРЛОГО	46,557,600.00	65,096,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	46,257,600.00	64,389,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	46,257,600.00	64,389,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	300,000.00	707,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300,000.00	707,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	50,965,176.72	68,083,257.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,965,176.72	68,083,257.26
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧЛЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,560,146.90	57,949,601.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,904,831.07	40,776,637.53
210101	Үндсэн цалин	29,984,831.07	36,764,025.53
210105	Гэрээт ажлын хөлс	1,920,000.00	4,012,612.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,013,955.11	5,508,900.00
210201	Тэтгэрийн даатгал	2,686,855.11	3,746,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	318,300.00	352,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	268,900.00	88,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	67,400.00	440,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	672,500.00	881,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,319,800.00	4,058,207.00
210301	Гэрэл, цахилгаан	315,300.00	408,207.00
210302	Тулш, халаалт	3,730,000.00	2,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	274,500.00	850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,377,360.00	1,663,700.00
210401	Бичиг хэрэг	149,200.00	252,400.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	429,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,000.00	205,300.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	798,160.00	777,000.00
2105	Нормативт зардал	618,000.00	407,000.00
210503	Нормын хувиас зөөлөн эдлэл	618,000.00	407,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2107	Томилголт, зочны зардал	314,000.00	330,000.00
210702	Дотоод албан томилолт	314,000.00	330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,081,000.00	392,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийслэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	921,000.00	232,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зөрчиллэг тогтоох	160,000.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,931,150.72	4,312,657.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	412,654.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,518,496.72	4,312,657.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,405,029.82	10,133,655.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшгудал	-	50,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,405,029.82	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,405,029.82	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	10,083,655.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	10,083,655.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,424,823.28	37,178,042.74
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,424,823.28	37,178,042.74



### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>47,487,600.00</b>	<b>65,096,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>47,487,600.00</b>	<b>65,096,100.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	47,187,600.00	64,389,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,187,600.00	64,389,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	300,000.00	707,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	707,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛТИЙН ДҮН (2)</b>	<b>47,487,600.00</b>	<b>65,096,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>47,487,600.00</b>	<b>65,096,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>44,082,570.18</b>	<b>54,962,444.53</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,060,361.07	40,776,637.53
210101	Үндсэн цалин	30,140,361.07	36,764,025.53
210105	Гэрээт ажлын хөлс	1,920,000.00	4,012,612.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,013,955.11	5,508,900.00
210201	Тэтгэврийн даатгал	2,686,855.11	3,746,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	318,300.00	352,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	268,900.00	88,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	67,400.00	440,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	672,500.00	881,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,319,800.00	4,058,207.00
210301	Гэрэл, цахилгаан	315,300.00	408,207.00
210302	Түлш, халаалт	3,730,000.00	2,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	274,500.00	850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,262,800.00	1,769,200.00
210401	Бичиг хэрэг	149,200.00	329,900.00
210402	Тээвэр, шатагчун	200,000.00	429,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,000.00	205,300.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	683,600.00	730,000.00
2105	Нормативт зардал	618,000.00	1,627,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	618,000.00	1,627,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2107	Томилголт, зочны зардал	314,000.00	330,000.00
210702	Дотоод албан томилголт	314,000.00	330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,081,000.00	392,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	921,000.00	232,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	412,654.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	412,654.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,405,029.82</b>	<b>10,133,655.47</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшчуулал	-	50,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,405,029.82	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,405,029.82	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	10,083,655.47
+ 213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	10,083,655.47



#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	352,928,413.40	0.00	2,024,588.70	0.00	354,953,002.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,928,413.40	0.00	2,024,588.70	0.00	354,953,002.10
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,928,413.40	0.00	2,024,588.70	0.00	354,953,002.10
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	352,928,413.40	0.00	2,024,588.70	0.00	354,953,002.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,928,413.40	0.00	2,024,588.70	0.00	354,953,002.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Галаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	37,178,042.74	0.00	37,178,042.74
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,928,413.40	0.00	39,202,631.44	0.00	392,131,044.84

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>64,389,100.00</b>	<b>54,305,444.53</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>64,389,100.00</b>	<b>54,305,444.53</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>64,089,100.00</b>	<b>54,255,444.53</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>49,298,400.00</b>	<b>40,776,637.53</b>
210101	Үндсэн цалин	43,239,800.00	36,764,025.53
210105	Гэрээт ажлын хөлс	6,058,600.00	4,012,612.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,508,900.00</b>	<b>5,508,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,746,100.00	3,746,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	352,600.00	352,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	88,100.00	88,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	440,700.00	440,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	881,400.00	881,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,550,000.00</b>	<b>4,058,207.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,700,000.00	408,207.00
210302	Түлш, халаалт	2,800,000.00	2,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	850,000.00	850,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,689,300.00</b>	<b>1,689,200.00</b>
210401	Бичиг хэрэг	250,000.00	249,900.00
210402	Тээвэр, шатахуун	429,000.00	429,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,300.00	205,300.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	730,000.00	730,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>330,000.00</b>	<b>330,000.00</b>
210702	Тогоод албан томилголт	330,000.00	330,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>412,500.00</b>	<b>392,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,500.00	232,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	160,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>300,000.00</b>	<b>50,000.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалт	300,000.00	50,000.00